

ТӨСӨЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.6.4 дэх заалт, 79.7 дахь хэсэг, 230 дугаар зүйлийн 230.1 дэх хэсэг, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын ... өдрийн хуралдааны 06/00 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1, 2.4 дэх заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

2.3.1.Архины зүйлс, дарс тус бүр 2 литр, шар айраг 3 литр, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй.

2.4.Энэ журмын 2.3.1-д заасан бараа 18 насанд хүрээгүй, хилээр гараад 24 цагийн дотор буцаж орж байгаа болон чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт орох зорчигчид хамаарахгүй.

ДАРГА

Б.АСРАЛТ